



**НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2015 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Дүүргийн сүлд тэмдэг, туг, түүнийг үйлдэх,  
хэрэглэх журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Дүүргийн сүлд тэмдэг, туг, түүнийг үйлдэх, хэрэглэх” журмыг хавсралт ёсоор баталсугай.
2. Журмын хэрэгжилтийг ханган ажиллахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА  Д.БАТ-ЭРДЭНЭ  


Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын 2015 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн  
01 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт



Чингэлтэй дүүргийн сүлд тэмдэг, туг түүнийг үйлдэх, хэрэглэх журам

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэ журмын зорилт нь дүүргийн сүлд тэмдэг, тугийг үйлдэх, дүрслэх, дээдлэн хэрэглэх үйл ажиллагааг зохицуулна.

1.2. Дүүргийн бэлгэдэл нь дүүргийн сүлд тэмдэг, туг мөн.

1.3. Дүүргийн сүлд тэмдэг, туг нь дүүргийн түүхэн уламжлал, онцлог, бат бэх оршин тогтнохын бэлгэдэл, цог хийморийг илэрхийлнэ.

Хоёр. Дүүргийн сүлд тэмдэг үйлдэх, дүрслэх

2.1. Чингэлтэй дүүргийн сүлд тэмдэг, тугийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 1995 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар баталсан, оюуны өмчийн бүртгэлд байгаа эх загварт заасан тэг, өргөн уртын харьцааг баримтална.

2.2. Дүүргийн сүлд тэмдгийг үйлдэх, энгэрийн болон дурсгалын тэмдэг, зурагт хуудас, төрөл бүрийн шошго, бусад зүйл дээр дүрслэхдээ хэмжээнээс үл хамааран энэхүү журмыг баримтална.

2.3. Дүүргийн сүлд тэмдгийг өнгө ялгаж буюу ялгахгүйгээр үйлдэж, дүрсэлж болно.

Гурав. Дүүргийн сүлд тэмдэг, тугийг хүндэтгэлтэйгээр байрлуулах, мандуулах, хэрэглэх

3.1. Дүүргийн туг, түүнийг үйлдэх

3.1.1 Дүүргийн туг нь мөнх хөх тэнгэрийн өнгөтэй байна. Тугны төв хэсэгт дүүргийн сүлд тэмдгийг байрлуулна. Тугны өргөн, урт нь 1:2-ын харьцаатай байна.

3.1.2 Дүүргийн тугийг хөх өнгийн, хээгүй, цулгуй эдээр үйлдэнэ.

3.1.3 Дүүргийн тугийг үйлдэх, дүрслэхдээ түүний хэмжээнээс үл хамааран дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон эх загварт заасан тэг, өргөн уртын харьцааг чанд баримтална.

3.1.4 Дүүргийн сүлд тэмдгийг туг дээр ямагт босоо байрлуулна.

3.2. Дүүргийн сүлд тэмдгийг дараах газруудад хүндэтгэлтэйгээр байрлуулах, мандуулах хэрэглэх.

3.2.1 Дүүргийн сүлд тэмдэг, тугийг Улсын баяр наадам, тэмдэглэлт ой, баяр, хүндэтгэлийн ёслол, хурал, зөвлөгөөн, урлаг спортын уралдаан, тэмцээн, тэдгээртэй адилтгах бусад арга хэмжээний үед тухайн арга хэмжээ зохион байгуулах газар, байранд байрлуулж, мандуулж болно.

3.2.2. Дүүргийн тугийг дүүрэг анх байгуулагдсан өдөр буюу жил бүрийн 9 дүгээр сарын 19 өдөр Чингэлтэй хайрханд ёслол, хүндэтгэл үзүүлэн мандуулна.

3.2.3. Дүүргийн сүлд тэмдэг, тугийг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж хүндэтгэлтэйгээр байрлуулан мандуулж болно.

3.2.4. Дүүргийн сүлд тэмдэг, тугийг ажил үйлсээрээ тэргүүлсэн баг хамт олонд хүндэтгэлтэйгээр гардуулж өгч аялуулж болно. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын зөвшөөрөлтэйгөөр ашиглах эрх олгоно.

3.2.5. Дүүргийн сүлд тэмдэг, тугийг иргэд хүндэтгэлтэйгээр мандуулж болно.

3.2.6. Дүүргийн тугийг дараах газар байнга байрлуулна:

а/ Дүүргийн Засаг даргын Тамгын газрын байр

б/ Засаг даргын Тамгын газрын Хурлын танхим, Ёслол хүндэтгэлийн танхим

в/ Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын албан тасалгаанд

г/ Дүүргийн Засаг даргын албан тасалгаанд

д/ Засаг даргын орлогчдын албан тасалгаанд

е/ Тамгын газрын даргын албан тасалгаанд

ё/ Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх алба хэлтсийн даргын албан тасалгаанд

ж/ Хорооны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг даргын албан тасалгаанд

з/ Сургууль цэцэрлэгийн байранд

и/ Харьяа байгууллагуудын байранд

Дөрөв. Дүүргийн сүлд тэмдэг, тугийг бусад сүлд, бэлгэ тэмдгүүдтэй байрлуулах.

4.1. Дүүргийн сүлд тэмдэг, тугийг Монгол Улсын төрийн сүлд, төрийн далбаатай байрлуулахдаа Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулийг баримтална.

4.2. Дүүргийн сүлд тэмдэг, тугийг гадаадын хотуудын сүлд, бэлгэ тэмдэг болон бусад зэрэглэл багатай бэлгэ тэмдгүүдтэй зэрэгцүүлэн байрлуулахдаа түүний эгц урдаас харахад сүлд, бэлгэ тэмдгүүд нь тэгш бус тоотой байвал дүүргийн сүлд тэмдэг, тугийг гол хэсэгт нь харин сүлд, бэлгэ тэмдгүүд нь тэгш тоотой байвал гол хэсгээс зүүн талын эхний байрлалд тус тус байрлуулна.

4.3. Дүүргийн сүлд тэмдгийг бусад зэрэглэл багатай бэлгэ тэмдэгтэй хамт дүрслэх тохиолдолд хэмжээгээр нь том тэдгээрээс дээгүүрт түвшинд байхаар тооцно.

Тав. Дүүргийн сүлд тэмдэг, тугийг хэрэглэх бусад тохиолдол

5.1. Дүүргийн сүлд тэмдгийг баяр, ёслолын арга хэмжээний үед гудамж талбайд.

5.2. Дүүргийг төлөөлөн олон улсын үзэсгэлэн яармаг, худалдаа зохион байгуулахад.

5.3. Нийслэл, аймагт зохион байгуулагдаж байгаа спортын уралдаан тэмцээн, спортын арга хэмжээний үед.

5.4. Дүүргийг төлөөлөн гадаад дотоодын уралдаан тэмцээнд оролцох баг тамирчдын хувцас, хэрэгсэл дээр тус тус байрлуулан хэрэглэнэ.

Зургаа. Дүүргийн сүлд тэмдэг, тугийг хамгаалах

6.1. Дүүргийн сүлд тэмдэг, тугийг байгууллага, аж ахуйн нэгж, иргэн хүндэтгэн дээдэлнэ.

6.2. Дүүргийн сүлд тэмдэг, тугийг гутаан доромжлох, архи, согтууруулах ундаа, тамхины сав, шошго дээр тус тус хэрэглэхийг хориглоно.

6.3. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын зөвшөөрөлгүйгээр дүүргийн сүлд тэмдэг, түүнтэй адил барааны тэмдгийг үйлчилгээнд ашиглавал “Дүүргийн сүлд тэмдэг, туг түүнийг үйлдэх, хэрэглэх журам”-ыг зөрчсөн гэж үзнэ.

6.4. “Дүүргийн сүлд тэмдэг, туг түүнийг үйлдэх, хэрэглэх журам”-ыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд “Төрийн бэлгэ тэмдгийн тухай” хуулийн 27 дугаар зүйлийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.5. Дүүргийн тугийг Чингэлтэй хайрханд мандуулах хүндэтгэлийн өдөр дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд архи, согтууруулах ундаа худалдаалахыг хориглоно.

Долоо. Журмын биелэлтэд тавих хяналт

7.1. Энэхүү журмын биелэлтэд Засаг даргын Тамгын газар, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Цагдаагийн хэлтэс, хорооны Иргэдийн Нийтийн Хурлын дарга, Тэргүүлэгч, хорооны Засаг дарга, бусад удирдах албан тушаалтан хяналт тавина.



**НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2015 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Чингэлтэй хайрханыг тайх  
тахилгын тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Төрийн тусгай хамгаалалттай Чингэлтэй хайрханыг тайх их тахилгыг 5 жилд, бага тахилгыг 2 жилд нэг удаа тус тус зохион байгуулсугай.

2. Чингэлтэй Хайрханы түүх домог, байгаль цаг уур, ургамал, амьтан, биологийн төрөл зүйл, экологийн тогтоц зэргийн талаар судалгаа хийн, иргэд, хүүхэд багачуудад байгаль дэлхийгээ хайрлах үзэл төлөвшүүлэх, хайрханыг, ойжуулах зэрэг иргэдийн оролцоотой бүтээлч ажил өрнүүлж, тайх тахилгын дэг жаяг, товыг Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хурлаар тухай бүр шийдвэрлүүлэн ажиллахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ